



Global Sustainable Tourism Council

Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөл – Зорих газрын шалгуур үзүүлэлт

Хувилбар 2.0
2019 оны 12 сарын 6

Гүйцэтгэлийн үзүүлэлт болон Тогтвортой хөгжлийн
зорилтууд

ДТАЖЗ-ийн Олон улсын стандартын ажлын хэсэг албан ёсоор баталж, ДТАЖЗ-ийн Захирлуудын зөвлөлөөс зорих газрын шалгуур үзүүлэлтийг ДТАЖЗ-ийн хууль тогтоомжийн дагуу албан ёсоор баталсан анхны шинэчилсэн хувилбар болно.

© Зохиогчын эрхээр баталгаажсан, 2019, Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын зөвлөл.
Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөл
Шуудангийн хайрцаг 96503 - #51887
Вашингтон, ДС 20090 АНУ
info@gstcouncil.org
www.gstcouncil.org

Удиртгал

Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөлийн (GSTC) шалгууруудыг Тогтвортой аялал жуулчлалын талаархи нэгдсэн ойлголт бий болгох зорилгоор гаргасан болно. Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөлийн (GSTC) зорих газрын шалгуурууд буюу албан бусаар “GSTC-D” хэмээн нэрлэдэг шалгуурууд нь жуулчдын зорих газарт тавих минимум үзүүлэлтүүд юм. Эдгээр үзүүлэлтүүд нь тогтвортой менежмент, нийгэм – эдийн засгийн нөлөөлөл, соёлын нөлөөлөл болон байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл гэсэн үндсэн дөрвөн сэдвүүдэд хуваагдах ба эдгээрийг аялал жуулчлалын бүхий л салбарт хэрэглэх боломжтой.

GSTC шалгуурыг тогтвортой байдлын стандартыг бүх салбарт боловсруулах олон улсын хэм хэмжээний талаар удирдамжаар хангадаг байгууллага болох ISEAL Alliance-ийн Стандарт тогтоох кодыг дагаж мөрдөхийг хичээн, шинэчлэн боловсруулсан болно. GSTC-D-ийн хамгийн сүүлийн шинэчилсэн найруулга нь 2019 онд хийгдсэн бөгөөд оролцогч талуудын хоёр удаагийн хэлэлцүүлэгт үндэслэсэн болно. Шалгуур үзүүлэлт, төлөвлөгөө боловсруулах талаархи мэдээллийг www.gstcouncil.org сайтаас авах боломжтой.

Шалгуур үзүүлэлт ямар хэрэгтэй вэ?

GSTC зорих газрын шалгуур үзүүлэлтүүд нь:

- Тогтвортой байдлын гэрчилгээ олгох үндэслэл болж үйлчилнэ,
- Тогтвортой болгохыг зорьж буй зорилтыг үндсэн удирдамжаар хангана,
- Хэрэглэгчдэд тогтвортой аялал жуулчлалын зорилтыг тодорхойлоход дэмжлэг үзүүлнэ,
- Тогтвортой байдлын тухай нийтэд мэдээлэх ба зорилтуудыг зөвшөөрүүлэхийн тулд мэдээллийн хэрэгслийн ашиглана,
- Гэрчилгээжүүлэх болон сайн дурын зорилтот түвшний хөтөлбөрүүд нь нийтэд зөвшөөрөгдсөн үндсэн түвшин, стандарттай нийцэх байдлыг хангана,
- Тогтвортой аялал жуулчлалын шаардлагуудыг хэрэгжүүлж эхэлж буй төрийн, төрийн бус болон хувийн хэвшилд ижил үйлчилнэ,
- Их сургуулиуд, аялал жуулчлалын сургууль гэх мэт боловсрол сургалтын байгууллагуудыг удирдамжийн үндэслэлээр хангана,
- Бусад газруудад манлайлж үлгэрлэн харуулах зэрэг хэрэглээний ач холбогдолтой юм.

Шалгуур нь юу хийсэн байх, хэрхэн хийх зорилгодоо хүрсэн эсэхийг илэрхийлэхгүй. Энэ үүрэг нь гүйцэтгэлийн үзүүлэлт, холбогдох сургалтын материал болон хэрэгжүүлэх хэрэгслийг ашигласнаар биелэгдэх бөгөөд GSTC шалгуурт зайлшгүй шаардагдах нэмэлт зүйл юм.

Шалгуур нь хэнд хамаатай вэ?

GSTC-D шалгуур нь зорих газарт¹ зориулагдсан. Шалгуур нь дан ганц байгууллагад хамаарахгүй ба өвөрмөц байдлаар тодорхойлох боломжтой газарт хамаарна. Шалгуур нь хэн хэрхэн хариуцах, эсвэл хэн хэрэгжүүлэхээс шалтгаалахгүйгээр нөхцөл байдлын тодорхойлолт нь тухайн зорих газрын онцлогт тохирсон байхыг шаарддаг.

¹ Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын (UNWTO) тодорхойлсноор “Зорих газар” гэдэг нь тухайн эсвэл хөрш зэргэлдээ газарт аялж бүтээгдэхүүн үйлчилгээ авах, үзэх болон хийх зүйлс, аялал жуулчлалын сүлжээ байгууллагууд нэг дор байршсан хоноглож болох физик газарзүйн орон зайлж хэлнэ. Энэ бол бүтээгдэхүүн, үйлчилгээ, аялал жуулчлалын үнэ цэнийн гинжин хэлхээний дагуу үйл ажиллагаа, туршлага, аялал жуулчлалын дүн шинжилгээ хийх үндсэн хэсэг юм. Зорих газар нь төрөл бүрийн сонирхогч талуудыг нэгтгэдэг бөгөөд илүү том зорилтот сүлжээнд нэгтгэж болно.

GSTC-D-ийн хамрах хүрээ өргөн, шалгуурыг аль ч газар нутагт ашиглах боломжтой ба эдгээр нь дэлхийн аль ч хэсэгт (хот, хөдөө, уул, эрэг эсвэл холимог) байж болно. Шалгуурыг томоохон (жишээлбэл, том хотууд эсвэл бүсүүд) эсвэл жижиг газруудад (жишээ нь, үндэсний цэцэрлэгт хүрээлэн, орон нутгийн кластерууд гэх мэт) хаана ч хэрэглэж болно.

GSTC-D нь ямар нэг байгууллага бус харин зорин очих газартай холбоотой бөгөөд олон шалгуурыг тухайн газрын тогтвортой аялал жуулчлалыг зохицуулах чиг үүрэгтэй байгууллагын удирдлагын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж болно. Ийм байгууллагатай байх нь шалгуур A1-д заасны дагуу GSTC-D-ийн гол шаардлага юм. Мөн энэ нь зөвхөн орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагын байгууллага байх төдийн бус төрийн болон хувийн хэвшлийн оролцоог шаарддаг болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Зарим шалгуурууд нь үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтын хувьд өөр боловч бие даасан бизнес эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хамаарна. Жишээ нь зочид буудал эсвэл төлбөрт үзмэр зэрэг зөвхөн ашгийн төлөө бизнесээс гадна музей, баяр наадам болон нийтийн байгууламж хөшөө дурсгал зэрэг ашгийн бус үйл ажиллагааг багтааж болно.

Гүйцэтгэлийн үзүүлэлт болон тогтвортой хөгжлийн зорилтууд

Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь зорих газрын шалгуурт нийцэж буйг хэмжих удирдамж болно. Гүйцэтгэлийн үзүүлэлт нь иж бүрэн бус ч GSTC C-D-ийн хэрэглэгчдийг хангалттай үзүүлэлтийн үр дүнг боловсруулах гарын авлага юм. Тэдгээр нь тодорхой багц эсвэл бүхэл бүтэн багц байхаар төлөвлөөгүй боловч GSTC C-D-ийн хэрэглэгчдийг өөрийн үзүүлэлтийг боловсруулан цаашид хөгжүүлэхэд хангалттай жишиг багц юм. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь зорих газрын шалгуурын нийцлийг үнэлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, нөхцөл байдал, хүчин зүйлийн баримт нотолгоогоор хангадаг.

Шалгуурыг ашигласнаар зорих газрыг 2030 тогтвортой хөгжлийн тунхаглал болон тогтвортой хөгжлийн 17 зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлнэ. Шалгуур бүрийн хувьд Тогтвортой хөгжлийн 17 зорилтын нэг буюу эсвэл хэд хэдэн зорилтуудтай нягт уялдаатай байдаг.

Албан хэл болон орчуулга

GSTC-ын шалгуур болон системийн албан ёсны хэл нь Англи хэл байна. GSTC веб эсвэл өөр гадаад хэлэнд орчуулсныг сургалт мэдээллийн зорилгоор ашиглах ба GSTC эсвэл стандарт эзэмшигч болон гэрчилгээ, магадлан итгэмжлэх эрх бүхий байгууллага хоорондын албан гэрээнд тусгаагүй л бол гэрчилгээ, итгэмжлэл олгох техникийн хөтөлбөрт ашиглахыг зөвшөөрөхгүй. Англи хэлнээс өөр хэл ашиглахыг зөвшөөрсөн тохиолдолд хоёрдмол утгатай зүйлсийг тайлбарлахдаа шалгуурын Англи хэл дээрхи албан ёсны хувилбарыг авч үзнэ.

Шилжилтийн үйл явц

GSTC-ын зорих газрын шалгуурын хувилбар 1.0-ээс 2.0-т шилжих үйл явц дараах байдлаар явагдана.

- Бодлого боловсруулах, сургалт явуулах зэрэг гэрчилгээтэй холбоогүй бусад зорилгоор хувилбар 2.0-г шууд ашиглана.
- GSTC зорих газрын стандартын хүлээн зөвшөөрөгдсөн Эзэмшигч нь өөрийн хэрэглэж буй стандартад өөрчлөлт оруулахыг хүсвэл шаардлагатай өөрчлөлт бүрийг GSTC-ийн үнэлгээнд нийцүүлэн 2021-12-31-с өмнө хоёр жилийн хугацаанд хийхийг зөвшөөрнө. Эзэмшигчид өөрсдийн стандарттаа өмнөх хувилбаруудтай нийцүүлэх хүсэлт гаргаж болох бөгөөд 2021 оны 6-р сарын 30-ны өдрөөс өмнө GSTC-ийн шаардлагатай өөрчлөлтийг хийх боломжтой.
- GSTC- зорих газрын шалгуурын хувилбар 1.0 дагуу зорих газрыг гэрчилгээжүүлэхээр итгэмжлэгдсэн байгууллагууд нь шинэчлэгдсэн 2.0 хувилбарыг нотолгооны хамт 2021 оны

12 сарын 31 гэхэд баталгаажуулах системд бүрэн нэгтгэсэн байх хэрэгтэй. Итгэмжлэгдсэн статусын хэвийн байдал нь шилжилтийн үед хэвээр байна. 2019 оны 12 сараас шинээр итгэмжлэгдэхээр хүсэлт гаргагчид нь хүсэлт гаргахаасаа өмнө GSTC-D хувилбар 2.0 эсвэл GSTC-ийн хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай дүйцэх стандарт хэрэглэж байгаа гэдгээ баталгаажуулах шаардлагатай.

GSTC-шалгуурын шинэчилсэн найруулга

2019 оны 12 сарын 6-с эхлэн (GSTC-D) хувилбар 2-ыг GSTC-ийн зорих газрын шалгуураар захирлуудын зөвлөлөөс албан ёсоор баталсан. GSTC-ийн зорих газрын шалгуурын (v2.0) хувилбар нь 2013 оны 12 сараас хойш шинэчлэгдсэн анхны албан хувилбар юм.

GSTC –нь өмнөх найруулгаас хойш 5 жилийн дотор тогтмол хянаагдаж, одоогийн хувилбар нь хүчинтэй байгаа эсэх болон албан ёсны засаж сайжруулах шаардлагатай байгаа эсэхийг тодорхойлдог. Дараагийн шинэчлэлт нь ойролцоогоор 2024 оны 12 сард хийгдэнэ. GSTC-ийн шалгуурын талаархи санал хүсэлтийг www.gstcouncil.org. –ийн шалгуур хэсгээр хэзээ ч хүлээн авах болно. Санал хүсэлтүүд нь баталгаажсан бол 2024 оны 12 сараас өмнө энэхүү хувилбарыг GSTC урьдчилан шинэчилж болно.

Шалгуурын бүтэц

Шалгуур нь дөрвөн хэсэгтэй , хэсэг бүр доор үзүүлснээр хоёр буюу гурван дэд хэсэгтэй болно. Хэсгүүд болон дэд хэсгүүдийн эрэмбэ нь сэдэв тус бүрийн ач холбогдлыг илэрхийлэхгүй.

A Хэсэг: Тогтвортой удирдлага <ul style="list-style-type: none"> A(a) Удирдлагын бүтэц болон хамрах хүрээ A(b) Оролцогч талуудын үүрэг, оролцоо A(c) Ачаалал болон өөрчлөлтийг удирдах B Хэсэг: Нийгэм – Эдийн засгийн тогтвортой байдал <ul style="list-style-type: none"> B(a) Орон нутгийн эдийн засагт үр өгөөж өгөх B(b) Нийгмийн сайн сайхан байдал, нөлөөллүүд 	C Хэсэг: Соёлын тогтвортой байдал <ul style="list-style-type: none"> C(a) Соёлын өвийг хадгалан хамгаалах C(b) Соёлын дурсгалт газруудаар аялах D Хэсэг: Байгаль орчны тогтвортой байдал <ul style="list-style-type: none"> D(a) Байгалийн өвийг хадгалах D(b) Нөөцийн удирдлага D(c) Хог хаягдлын менежмент ба хүлэмжийн хийг бууруулах
---	--

ДТАЖЗ - Зорих газрын шалгуур - хувилбар2.0

Шалгуур	Үзүүлэлтүүд	ТХЗо-д
А ХЭСЭГ: Тогтвортой байдлын удирдлага		
A(а) Удирдлагын бүтэц болон хамрах хүрээ		
A1 Зорих газрын удирдлага менежментийн үүрэг хариуцлага Зорих газар нь иргэний нийгэм, хувийн хэвшил болон төрийн байгууллагуудыг багтаасан аялал жуулчлалын тогтвортой байдалд чиглэсэн үүрэг хариуцлага бүхий хуулийн этгээд буюу нэгж, бүлэг эсвэл хороотой байна. Энэ нэгж нь нийгэм эдийн засаг, соёл, байгаль орчны асуудлаар удирдлага менежментийн үүрэг, хяналт, хэрэгжүүлэх чадамжаа тодорхойлно. Мөн нэгж нь хангалттай санхүүжилттэй, санхүү болон үйл ажиллагааны хувьд тогтвортой, ил тод байх зарчмыг мөрддөг, тогтвортой байдлын талаар туршлагатай боловсон хүчин бүхий байх бөгөөд зорих газрын удирдлагыг хэрэгжүүлэгч бусад байгууллагатай хамтран ажилладаг байна.	a. Бүлгийн бүтэц, үүрэг хариуцлагыг харуулсан нотлох баримт. b. Санхүүгийн төлөвлөгөө, төсөв нь одоо болон ирээдүйн санхүүжилтийн эх үүсвэрийг харуулна. c. Бусад байгууллагын харилцаатай холбогдох нотлох баримт d. Байнгын болон гэрээт ажилчдын бүртгэл, холбогдох туршлагыг харуулна. e. Гэрээ байгуулах болон бизнесийн үйл ажиллагаанд ил тод тогтвортой байдлын зарчмууд баримталж буй эсэхийг харуулдаг удирдлагын удирдамж, үйл явц	 16 PEACE, JUSTICE AND STRONG INSTITUTIONS  17 PARTNERSHIPS FOR THE GOALS
A2 Зорих газрын удирдлагын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө Зорих газар нь тогтвортой байдлын зарчим дээр үндэслэсэн олон нийтэд нээлттэй, өргөн цар хүрээлтэй, сонирхогч талуудын оролцоотойгоор боловсруулсан урт хугацааны зорилтот удирдлагын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Стратеги нь аялал жуулчлалын хөрөнгийг тодорхойлон үнэлж нийгэм эдийн засаг, соёл, байгаль орчны асуудал, эрсдлүүдийг тооцдог. Энэхүү стратеги нь зорилтот чиглэл дэх тогтвортой хөгжлийн өргөн хүрээний бодлого, үйл ажиллагаатай холбоотой	a. Одоогийн зорих стратеги, үйл ажиллагааг тодорхойлсон, нийтлэгдсэн баримт бичиг b. Стратеги / төлөвлөгөө нь ойлгомжтой, онлайнаар харах боломжтой c. Төлөвлөгөөг боловсруулахад оролцогч талуудын зөвлөгөө, уулзалтын баримтууд d. Тогтвортой хөгжлийн зарчим, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө, асуудал, эрсдлийн үнэлгээ. e. Тогтвортой хөгжлийн бодлогыг өргөн хүрээнд хэрэгжүүлэх стратеги / үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан тодорхой заалтууд (SDGs хэрэгжүүлэлтийг оролцуулаад), буюу уг заалтуудыг бодлогын баримт бичигүүдэд тусгасан байдал,	 17 PARTNERSHIPS FOR THE GOALS

бөгөөд нөлөөлдөг.		
A3 Хяналт, мониторинг ба тайлагнан Зорих газар нь нийгэм, эдийн засаг, соёл, экологид аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийн мониторинг хийх, хариу арга хэмжээ авах системийг хэрэгжүүлнэ. Үйл ажиллагаа, үр дүнг тогтмол хянаж, үнэлж, нийтэд мэдээлнэ. Мониторингийн системийг тодорхой хугацаанд шалгаж байна.	<ul style="list-style-type: none"> a. Төлөвлөгөөт зорилтууд болон нийгэм эдийн засаг, соёл хүрээлэн буй орчны хэмжигдэхүйц тоон үзүүлэлтүүд тодорхойлогдсон байдал b. Эдгээр үзүүлэлтийг хэмжиж жилд нэгээс доошгүй удаа бүртгэж нийтэд мэдээлнэ c. Үйл ажиллагаа, үр дүнг хянаж тайлагнасан баримтууд d. Мониторингийн системийн өмнөх шалгалт болон дараагийн шалгах хуваарь 	 12 RESPONSIBLE CONSUMPTION AND PRODUCTION
A(b) Сонирхогч талуудын оролцоо		
A4 Байгууллагын оролцоо болон тогтвортой байдлын стандартууд Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд тогтвортой байдлын талаар тогтмол мэдээлж, үйл ажиллагаагаа илүү тогтвортой болгоход нь дэмжиж, дэмжиж ажилладаг. Зорих газар нь аялал жуулчлалын байгууллагуудад тогтвортой хөгжлийн асуудлууд болон үйл ажиллагаагаа илүү тогтвортой байлгахад тусалж дэмжихийн тулд тогтмол мэдээллэж байна. Зорих газар нь батлагдсан тогтвортой байдлын стандартуудыг дэмжих, боломжтой бол GSTC-I-ийн хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд болон GSTC-I-ийн магадлан гэрчилгээжүүлэх тогтолцоог аялал жуулчлалын байгууллагуудад сурталчилна. Зорих газар нь тогтвортой байдлын гэрчилгээтэй байгууллагуудын жагсаалтыг нийтэлдэг.	<ul style="list-style-type: none"> a. Аялал жуулчлалын байгууллагуудтай тогтвортой байдлын асуудлаар тогтмол харилцаж байгаа баримт (хэвлэл мэдээлэл, хурал, шууд харилцаа холбоо) b. Аялал жуулчлалын компаниудад тогтвортой байдлын зөвлөгөө дэмжлэг өгөхөд боломжтой байдал c. Аялал жуулчлалын тогтвортой байдлын стандартаар баталгаажуулсан бизнесийн тоо, хувь (мөн GSTC хүлээн зөвшөөрөгдсөн / итгэмжлэгдсэн эсэх), өргөн хүрээг хамарсан зорилтот түвшин d. Гэрчилгээжүүлэх схемийн сурталчилгааны нотолгоо e. Гэрчилгээжсэн аялал жуулчлалын байгууллагуудын шинэчилсэн жагсаалт 	 12 RESPONSIBLE CONSUMPTION AND PRODUCTION
		 17 PARTNERSHIPS FOR THE GOALS

A5 Байнгын оршин суугчдын оролцоо, санал хүсэлт <p>Зорих газар нь тогтвортой хөгжлийн төлөвлөлт, менежментэд олон нийтийн оролцоог дэмжиж сурталчилдаг байна. Аялал жуулчлалын тогтвортой байдал, зорих газрын менежментийн талаарх орон нутгийн иргэдийн хүсэл эрмэлзлэл, эргэлзээ, сэтгэл ханамжийг тогтмол хянаж, нийтэд мэдээллэж, шаардлагатай арга хэмжээг авна. Зорих газар нь тогтвортой аялал жуулчлалын боломжууд болон шаардлагуудын талаархи нутгийн иргэдийн ойлголтыг дээшлүүлэх, чадамжийг сайжруулах системтэй байдаг.</p>	<ul style="list-style-type: none"> a. Зорих газрын төлөвлөлт, менежментэд олон нийтийн оролцоог дэмжих, сурталчилсан байдлын нотолгоо b. Оролцооны хэлбэр болон түвшний талаархи мэдээлэл c. Байнгын оршин суугчдын санал асуулга болон аялал жуулчлалын бусад асуудлын талаархи санал хүсэлтийн механизм d. Байнгын оршин суугчдын санал хүсэлтэнд өгсөн хариу арга хэмжээний нотолгоо e. Байнгын оршин суугчдад өгсөн аялал жуулчлалын боловсрол, сургалт мэдээллийн хөтөлбөр 	<div style="display: flex; align-items: center;"> <div style="text-align: right; margin-right: 10px;"> 17 PARTNERSHIPS FOR THE GOALS </div> <div style="text-align: center;">  </div> </div> <div style="display: flex; align-items: center;"> <div style="text-align: right; margin-right: 10px;"> 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES </div> <div style="text-align: center;">  </div> </div>
A6 Аялагчдын оролцоо болон санал хүсэлт <p>Зорих газар нь аялагчдын сэтгэл ханамж болон зорих газрын тогтвортой байдал, чанар, туршлагыг хянах, ил тод мэдээллэх, шаардлагатай бол хариу арга хэмжээ авах системтэй байна. Аялагчдад зорих газар дахь тогтвортой байдлын асуудлууд болон тэдгээрийг шийдвэрлэх боломжийн тухай мэдээлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> a. Аялагчдын санал асуулга/ санал хүсэлтийн механизмыг хэрэгжүүлэлт ба мэдээлэл b. Санал асуулга болон судалгаанд аялагчдын тогтвортой байдлын асуудлын талаархи санал бодлыг тусгасан байдал c. Аялагчдын санал асуулга/ судалгааны дүгнэлтээр авах арга хэмжээний нотолгоо d. Тогтвортой байдлын асуудлууд болон түүнд хэрхэн хариулах тухай аялагчдаас авсан судалгаа мэдээллийн жишээ 	<div style="display: flex; align-items: center;"> <div style="text-align: right; margin-right: 10px;"> 12 RESPONSIBLE CONSUMPTION AND PRODUCTION </div> <div style="text-align: center;">  </div> </div> <div style="display: flex; align-items: center;"> <div style="text-align: right; margin-right: 10px;"> 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES </div> <div style="text-align: center;">  </div> </div>
A7 Мэдээлэл, сурталчилгаа <p>Зорих газрын тухай аялагчдад зориулсан мэдээлэл, сурталчилгаа нь тогтвортой байдлын шаардлага, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар багтаасан байна. Маркетингийн мессэж, мэдээлэл болон бусад харилцаанууд нь зорих газрын үнэ цэнэ ба тогтвортой байдал, байгаль соёлын өвд хүндэтгэлтэй хандах хандлагыг тусгана.</p>	<ul style="list-style-type: none"> a. Тухайн мэдээлэл болон сурталчилгааны материал нь үнэн зөв байна. b. Зорих газрын сурталчилгаа, мэдээллийн үнэн зөв, зохистой байдлыг хянах үйл ажиллагааг бүрдүүлсэн байна.. c. Мэдээлэл, харилцааны агуулга, хүртээмжийн талаар орон нутгийн иргэд, байгаль орчин, соёлын холбогдо байгууллагуудтай зөвлөлдсөн тухай нотолгоо. 	<div style="display: flex; align-items: center;"> <div style="text-align: right; margin-right: 10px;"> 12 RESPONSIBLE CONSUMPTION AND PRODUCTION </div> <div style="text-align: center;">  </div> </div> <div style="display: flex; align-items: center;"> <div style="text-align: right; margin-right: 10px;"> 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES </div> <div style="text-align: center;">  </div> </div>
<u>A(c) Ачаалал болон өөрчлөлтийн менежмент</u>		

A8 Аялагчдын тоо, үйл ажиллагааны менежмент Зорих газар нь аялагчдын менежментийн системтэй байх ба үүнийг тогтмол хянана. Орон нутгийн эдийн засаг, олон нийт, соёлын өв, хүрээлэн буй орчны хэрэгцээг тэнцвэржүүлэхийн тулд аялагчдын тоо хэмжээ, үйл ажиллагааг хянах, шаардлагатай үед багасгах, нэмэгдүүлэх зорилгоор арга хэмжээ авдаг байна.	<ul style="list-style-type: none"> a. Зорих газрын менежментийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө нь улирлаас хамааран аяллын хуваарийг багтаасан байна. b. Аялагчдын тоо хэмжээний өөрчлөлтийг жилийн туршид хамгийн их зорчдог газруудыг оролцуулан хянана. c. Аялагчдын тоо хэмжээ, үйл ажиллагааны нөлөөллийг орон нутаг, оролцогч талуудын ажиглалт санал хүсэлтээр тодорхойлно. d. Аялагчдын урсгал болон нөлөөллүүдийг удирдах талаар авсан арга хэмжээ. e. Маркетингийн стратеги болон зорилтот зах зээлийг сонгоходоо аялах хэлбэр, үйл ажиллагааны нөлөө, зорилтот хэрэгцээг авч үзсэн байдал. 	 12 RESPONSIBLE CONSUMPTION AND PRODUCTION  11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES
A9 Төлөвлөлтийн журам болон хөгжлийн удирдлага Зорих газар нь хөгжлийн чиг хандлага, мөн хөгжлийн байдал чанар, байгаль, эдийн засаг, нийгэм-соёлын нөлөөллийн үнэлгээ болон газар ашиглалт, эвдрэл, барилгажилтын талаар нэгтгэн удирдах дүрэм журам, зохицуулалтын удирдамжтай байна. Аялал жуулчлалын зорилгоор эд хөрөнгө түрээслэх болон хөнгөлөх зэрэг үйл ажиллагааг тодорхой журмаар зохицуулна. Бодлого журам, удирдамжийг олон нийтийн оролцоотойгоор боловсруулж тэдэнд мэдээлж хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> a. Гарчиг болон огноогоор тодорхойлогдсон хөгжлийн хяналтын бодлого зохицуулалтын удирдамж болох баримт бичиг. b. Нөлөөллийн үнэлгээний шаардлагууд нь урт хугацааны асуудлыг шийдвэрлэх зорилтын хүрээнд хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгэм соёлын нөлөөллүүдийг зорилтуудыг тусгасан байдал. c. Аялал жуулчлалын үйл ажиллагаа болон эд хөрөнгийг түрээслэх тусгай дүрэм журам түүний хэрэглээ, хэрэгжилтийг нотлох баримт. d. Хөгжлийн бодлого, дүрэм журмуудад олон нийтийн оролцоог хангасан тухай баримт нотолгоо e. Тухайн нутаг дэвсгэрт аялал жуулчлал хөгжүүлэх санал тавьсан эсвэл гүйцэтгэсэн бол тухайн орон нутгийн хүмүүс эсвэл үндэсний цөөнхтэй зөвшилцэж зөвлөгөө авсан тухай баримт нотолгоо. f. Төлөвлөлт, хөгжил болон хэрэгжүүлэх үе шатны бодлогыг тодорхойлох мэдээлэл, харилцааны баримт нотолгоо. 	 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES  9 INDUSTRY, INNOVATION AND INFRASTRUCTURE

A10 Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох Зорих газар нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, боломжуудыг тодорхойлно. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги нь аялал жуулчлалын байгууламжийн байршил тогтоох, төлөвлөж хөгжүүлэх менежмент хийхэд чиглэдэг. Уур амьсгалын урьдчилсан мэдээ, тохиолдож болох нөхцөл байдал, эрсдлийн тухай мэдээллийг аялагчид, байгууллагууд, орон нутгийн иргэдэд хүргэдэг байна.	<ul style="list-style-type: none"> a. Зорих газрын менежментийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө нь уур амьсгалын асуудлуудыг тодорхойлсон байна. b. Дүрэм журмууд, аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх үйл ажиллагаануудыг уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаварт уялдуулсан байна. c. Уур амьсгалын эрсдлийн үнэлгээ, одоогийн болон ирээдүйн эрсдлүүд – Олон нийтэд нээлттэй байна. d. Орон нутгийн экосистемүүд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход нөлөөлж буй нөлөөллийг харуулсан баримт нотолгоо. e. Уур амьсгалын өөрчлөлтийн талаархи мэдээллийн олон нийтэд нээлттэй ил тод байдал. 	
A11 Эрсдэл хямралын менежмент Зорих газар нь шаардлагатай тохиолдолд тухайн байдалд тохирсон авах арга хэмжээний төлөвлөгөө, эрсдлийг бууруулах, хямралын менежменттэй байна. Гол үйл ажиллагаанууд нь байнгын оршин суугчид, аялагчид болон аж ахуйн нэгж байгуулагуудад чиглэсэн байна. Үйл ажиллагаа ба нөөц нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд тогтмол шинэчлэгдэж байна.	<ul style="list-style-type: none"> a. Зорих газарт эрсдлийг бууруулах, хямралыг удирдах, онцгой үед авах арга хэмжээний баримтжуулсан төлөвлөгөө. b. Уг төлөвлөгөө нь байгалийн гамшиг, терроризм, эрүүл мэнд, нөөцийн хомсдол, байршилтай холбоотой бусад өргөн хүрээний эрсдлийг багтаасан байдал. c. Онцгой байдлын үед болон дараа нь ашиглах харилцаа холбооны журам. d. Эрсдэл, гамшигийн менежментийн талаархи сургалт мэдээллийг орон нутагт түгээх хөтөлбөр 	 


В ХЭСЭГ: Нийгэм Эдийн Засгийн тогтвортой байдал

B(а) Эдийн засгийн үр өгөөжийг орон нутагт хүргэх

B1 Аялал жуулчлалын эдийн засгийн хувь нэмрийг хэмжих

Зорих газрын эдийн засагт аялал жуулчлалын шууд болон шууд бус эдийн засгийн хувь нэмрийг хянаж олон нийтэд мэдээлнэ. Аялагчдын тоо хэмжээний түвшин, зарцуулсан мөнгө, хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө оруулалт зэрэг зохих хэмжигдэхүүнүүдийн мониторинг болон мөн эдийн засгийн үр өгөөжийг хуваарилах баримт нотолгоо орно.


- a. Эдийн засгийн мэдээлэл цуглуулах программ.
- b. Зорих газарт үзүүлж буй аялал жуулчлалын эдийн засгийн шууд болон шууд бус үр өгөөжийн жилийн тайлан.
- c. Эдийн засгийн нөлөөллийг хэмжих өргөн хүрээг багтаасан өгөгдлүүд (жишээ нь – тоо хэмжээ, зарцуулалт, хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө оруулалт, зорих газарт эдийн засгийн үр өгөөжийг хуваарилах).



B2 Зохистой ажил мэргэжлийн боломжууд

Зорих газар нь аялал жуулчлалд сургах, мэргэжлийн карьер хөгжлийн боломжуудаар хангах боломжтой. Зорих газрын аялал жуулчлалын байгууллагууд нь тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэх, сургалт, хөгжиж дэвших, эрүүл аюулгүй ажлын байр, амьдрах цалин хөлс зэрэг боломжоор тэгш хангах үүрэгтэй.


- a. Холбогдох ур чадварын сургалтын хөтөлбөрийг орон нутагт боломжтой байдлаар хангасан байдал.
- b. Зохистой ажил, мэргэжлийн боломжуудаар хангахад аялал жуулчлалын байгууллагуудын үүрэг оролцоо, амлалт.
- c. Орон нутгийн иргэд, түүний дотор эмэгтэйчүүд, залуус, насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг суралцах, хөдөлмөр эрхлэх боломжуудаар дэмжсэн байдал.
- d. Хөдөлмөрийн нөхцлүүдийг шалгах, гомдол заргыг хүлээн авах / шийдвэрлэх сувгууд (үйлдвэрчний эвлэлүүдийн оролцоо гэх мэт).



B3 Орон нутгийн бизнес эрхлэгчид, яармаг худалдааг дэмжих

Зорих газар нь орон нутгийн аж ахуйн нэгжүүд, хангамжийн сүлжээ, тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжих замаар орон нутгийн эдийн засагт аялал жуулчлалын зардлыг хадгалахыг дэмжих зорилготой. Тухайн бус нутгийн байгаль соёлыг тусгасан, харилцан ашигтай худалдааны зарчимд тулгуурласан бүтээгдэхүүнийг орон

- a. Зорих газарт байгаа аялал жуулчлалтай холбоотой жижиг дунд бизнес эрхлэх зөвлөгөө, санхүү эсвэл бусад дэмжлэг үзүүлсэн байдал.
- b. Орон нутгийн аялал жуулчлалтай холбоотой жижиг дунд бизнес эрхлэгчдийг зах зээлд нэвтрэхэд дэмжих
- c. Орон нутгаас бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авалт хийхэд орон нутгийн аялал жуулчлалын байгууллагуудаас дэмжих үйл ажиллагаа
- d. Орон нутгийн тариаланчид, гар урчууд,



<p>нутгаас тогтвортой худалдан авч, хөгжүүлэхийг дэмжинэ. Эдгээрт хоол ундаа, гар урлал, ардын урлагын үзүүлбэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зэрэг орно.</p>	<p>хүнсний үйлдвэрлэгчдэд аялал жуулчлалын өргтийн сүлжээнд оролцоход нь туслах санал санаачлага</p> <p>e. Орон нутгийн бүтээгдэхүүн, гар урлалыг таниулж, сурталчлан боломжтой бол аялагчдад зарж борлуулах боломжийг бүрдүүлэх.</p>	
--	---	--

B(b) Нийгмийн сайн сайхан болон нөлөөлөл

B4 Орон нутгийг дэмжих <p>Зорих газар нь аж ахуйн нэгж байгууллага, аялагчид болон олон нийтээс орон нутагт дэмжлэг үзүүлэх, тогтвортой байдлын санаачлагуудыг хариуцлагатайгаар хэрэгжүүлэх системтэй байна.</p>	<p>a. Орон нутгийн аялал жуулчлалын байгууллагууд нь орон нутгийн иргэдийн тогтвортой байдлын талаархи санаачлагыг дэмжиж, тусалдаг байна.</p> <p>b. Аялагчдаас орон нутгийг дэмжих, тэдний тогтвортой хөгжлийн санаачлагын хөтөлбөрүүдтэй байх, сурталчилдаг байх.</p> <p>c. Сайн дурын ажил, олон нийтийн оролцоо нь ямар нэгэн тулгалт, дарлал мөлжлөгийг агуулдаггүй байх.</p>	 
B5 Дарлал, ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх <p>Зорих газар нь хүний эрхийн олон улсын стандартуудыг хэрэгжүүлнэ. Хүний наймаа, орчин үеийн боолчлол, арилжааны, бэлгийн болон бусад хэлбэрээр, хэн нэгнийг, ялангуяа хүүхэд, өсвөр насынхан, эмэгтэйчүүд, ЛГБТ, бусад цөөнхүүдийн эсрэг буюу ялгаварлан гадуурхах, доромжлооос урьдчилан сэргийлж мэдээлэх хууль эрх зүй болон ёс зүйн дүрэм, бодит практиктай байна. Холбогдох дүрэм, журам болон тогтоосон практикуудыг мөрдөж, олон нийтэд ил тод мэдээлнэ.</p>	<p>a. Хүний эрх, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхахтай холбоотой тухайн газар нутагт хамаарах хууль тогтоомжуудын тайлбар /Нэр, огноо/</p> <p>b. Дээрх хууль тогтоомж, холбогдох практикийг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт нотолгоо/ Аялал жуулчлалын байгууллага, аялагчидад хамаарах/.</p> <p>c. Хүний наймаа, хүүхдийн хөдөлмөр, боолчлол, зэрэг хүний эрхийн болон эрсдлийн ба нөлөөллийн дүн шинжилгээг тогтмол хийдэг байдал.</p> <p>d. Зорих газар, аялал жуулчлалын гол оролцогчид нь аялал жуулчлалд хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртөхөөс хамгаалах ёс зүйн дүрмийг баталж гарын үсгээ зурж баталсан байна.</p>	 
B6 Өмчлөл болон хэрэглэгчийн эрх <p>Өмчлөл, хөрөнгө худалдан авахтай холбоотой хууль тогтоомжуудыг баримтжуулан мөрдөнө. Үүний дагуу орон нутаг болон уугуул иргэдтэй зөвшилцөж, олон нийтийн зөвлөгөөг авч, нөхөн олговорыг тохиролцож, урьдчилан мэдээллэж зөвшилцөхгүйгээр нүүлгэн шилжүүлэхийг зөвшөөрдөггүй. Хууль,</p>	<p>a. Зорих газрын нөөцийг ашиглах, эзэмших болон өмчлөх эрхийн зохицуулалттай холбогдох хууль тогтоомжийн үндэслэл /Нэр, Огноо/.</p> <p>b. Холбогдох хууль тогтоомжийн орон нутгийн уугуул иргэдийн эрх, нийтийн зөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх үндэслэл.</p> <p>c. Аялал жуулчлалын хөгжил, үйл ажиллагаатай холбоотой дээрх хуулиудын хэрэгжилтийн баримт нотолгоо.</p>	 

тогтоомж нь хэрэглэгчийн эрхийг хамгаалж байгаль, соёлын гол нөөцтэй харилцах эрхийг нээнэ.	d. Нийтийн асуулга, зөвшилцөл, нөхөн олговорын баримт нотолгоо.	
B7 Аюулгүй байдал Зорих газар нь аялагчид, оршин суугчдын хэрэгцээнд нийцсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдлийг хянах чиглэлээр олон нийтэд мэдээлэх, холбогдох арга хэмжээ авах системтэй байна.	a. Зорих газарт аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээ сайн хөгжсөн идэвхитэй байна. b. Аялагчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тохиорох эрүүл мэнд, аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлдэг байна. c. Аялал жуулчлалын байгууламжууд нь аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартад нийцэж байгаа эсэхийг хянан шалгадаг байна.	 
B8 Бүх хүмүүст аялахад нээлттэй байх Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад тусгай хэрэгцээ шаардлагатай хүмүүс байгаль соёлын ач холбогдол бүхий үзмэрүүд, байгууламж, үйлчилгээг авах, нэвтрэн ороход нээлттэй байна. Үзмэр, байгууламжид шууд нэвтрүүлэх боломжгүй бол тухайн газрын бүрэн бүтэн байдал, тусгай шаардлага бүхий хүмүүс зэргийг харгалzan үзэж шийдлийг боловсруулж хэрэгжүүлэх замаар нэвтрүүлнэ. Үзмэрүүд, байшин, барилга байгууламжид нэвтрэх болон бусад холбогдох үйлчилгээний талаар мэдээлэл хүртээмжтэй байна.	a. Үзмэрүүд, барилга байгууламж, үйлчилгээний нэвтрэх зохицуулалтын талаар дүрэм журам стандарт байгаа эсэх. b. Нийтийн зориулалттай үйлчилгээнд стандартыг тууштай хэрэгжүүлж байгаа байдал. c. Аялж болох газар, үйлчилгээний хувь хэмжээ/ харьцааны талаархи хэрэглэж болох мэдээлэл. d. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зорчиход зориулсан зохицуулалтыг сайжруулах хөтөлбөрүүдийн баримт нотолгоо. e. Зорих газрын тухай хэрэглэж болох бүх л мэдээлэлд нэвтрэн орох тухай тусгасан байдал. f. Гол газруудад зорчин нэвтрэх тухай аялагчдад зориулсан мэдээлэлд тусгасан байдал.	 

С ХЭСЭГ: Соёлын тогтвортой байдал

C(a) Соёлын өвийн хамгаалалт

C1 Соёлын эд зүйлсийг хамгаалах <p>Зорих газар нь хүний бүтээсэн болон бусад соёлын үнэт зүйлсийг хамгаалах, нөхөн сэргээх, үнэлэх, соёлын үнэ цэнэ бүхий газар нутгуудыг бий болгох зэрэг бодлого системтэй байна.</p>	<ul style="list-style-type: none"> a. Эмзэг байдлын үзүүлэлт, үнэлгээ бүхий соёлын үнэт зүйлсийн жагсаалт. b. Үнэт зүйлсийг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөр. c. Аялал жуулчлалаас орох орлогыг соёлын үнэт зүйлсийг хадгалахад дэмжлэг үзүүлэх механизм. 	 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES
C2 Соёлын олдворууд <p>Зорих газар нь түүх, археологийн олдворыг зохих ёсоор үзүүлж харуулах, худалдах, бэлэглэх зэргийг зохицуулсан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. Холбогдох хуулиудыг аялал жуулчлалын байгууллага, аялагчид болон нийтэд мэдээлж хэрэгжүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> a. Тухайн газарт хамаарах түүхэн олдворуудтай холбоотой хууль, журмын жагсаалт (гарчиг, огноо). b. Холбогдох хууль тогтоомжийг аялал жуулчлалын байгууллагууд болон аялагчдад мэдээлж буй нотолгоо. c. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа тухай нотолгоо. 	 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES
C3 Биет бус өв <p>Зорих газар нь тухайн нутгийн уламжлал, урлаг, дуу хөгжим, хэл соёл, хоол ундаа болон орон нутгийн өвөрмөц байдал, онцлог шинж чанарыг багтаасан биет бус соёлын өвийг тэмдэглэж, хамгаалах үйл ажиллагааг дэмжинэ. Орон нутгийн ахуй, соёл уламжлалыг үзүүлж олшруулах болон тайлбарлахдаа мэдрэмжтэй, хүндэтгэлтэй хандаж, орон нутгийн иргэдийн хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд тэднийг татан оролцуулж, аялагчдад жинхэнэ бодит туршлагыг санал болгоно.</p>	<ul style="list-style-type: none"> a. Биет бус соёлын өвийн жагсаалт болон тодорхойлолт b. Биет бус соёлын өвийг тэмдэглэх жишээ, аялагчдын туршлага (үйл ажиллагаа, өвөрмөц бүтээгдэхүүн гэх мэт). c. Соёлын биет бус өвд тулгуурласан аялагчдын туршлагыг хөгжүүлж, хүргэхэд нутгийн уугуул иргэдийн оролцоог нотлох баримт. d. Биет бус соёлын өвийн туршлага хуваалцсан аялагчид, уугуул иргэдийн санал хүсэлт. 	 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES  12 RESPONSIBLE CONSUMPTION AND PRODUCTION
C4 Уламжлалт зорчин нэвтрэх байдал <p>Байгаль соёлын өв, үзмэрүүдийн байдалд хяналт тавьж, хамгаалах ба шаардлагатай үед сэргээн засварлах үйл ажиллагаанд оролцоход орон нутгийн уугуул иргэдийн зорчин</p>	<ul style="list-style-type: none"> a. Нутгийн уугуул иргэдийг байгаль соёлын дурсгалт газарт нэвтрэх байдлын хяналт. b. Уламжлалын дагуу уугуул иргэд зорчин нэвтрэхийг хангаж байгаа нотолгоо. c. Уугуул иргэдийн зорчин нэвтрэхийг сэргээх буюу хамгаалах тусгай арга хэмжээнүүд. 	

нэвтрэхэд дэмжлэг үзүүлнэ.		
C5 Оюуны өмч Зорих газар нь нийгэм, хувь хүний оюуны өмчийн эрхийг хадгалж, хамгаалахад дэмжлэг үзүүлэх системтэй байна.	<ul style="list-style-type: none"> a. Зорих газарт хамаарах оюуны өмчийн хууль, тогтоомжийн жагсаалт (гарчиг, огноо). b. Оюуны өмчийн харилцааг аялал жуулчлалын оролцогч талуудад хүргэсэн байдал. c. Аялагчдад зориулсан соёлын мэдээлэл нь оюуны өмчийн эрхээр хамгаалагдсаны баталгаа. 	 16 PEACE, JUSTICE AND STRONG INSTITUTIONS
C(b) Соёлын дурсгалт газруудад зочлох		
C6 Соёлын дурсгалт газрууд дахь аялагчдын менежмент Зорих газар нь соёлын дурсгалт газрууд түүний орчимд аялагчдыг удирдах системтэй байх бөгөөд тухайн газруудын шинж чанар, хүчин чадал, эмзэг байдлыг харгалзан жуулчдын урсгалыг оновчтой болгож, сөрөг нөлөөллийг багасгахыг эрмэлзэнэ. Онгон зэлүүд эмзэг газар нутаг, соёлын арга хэмжээнд оролцон зочлоход биеэ авч явах талаар удирдамжийг зочид, тур оператор, хөтөч наарт тухайн үед болон аялахаас өмнө өгдөг байна.	<ul style="list-style-type: none"> a. Зорих газраар аялан өнгөрөхөд соёлын дурсгалт газарт аялагчдын тоо ба хөдөлгөөний нөлөөллийн мониторинг. b. Соёлын дурсгалт газар, түүний орчимд аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөлөлийг удирдах үйл ажиллагааны баримт нотолгоо. c. Эмзэг газар нутаг, соёлын арга хэмжээнд оролцох аялагчдын биеэ авч явах байдлын талаар хэвлэгдсэн удирдамжтай эсэх, түгээлт. d. Тур оператор, аяллын хөтөч болон бусад оролцогчид соёлын дурсгалт газарт аялагчийг удирдах ёс зүйн дүрэм, практик. e. Хөтчүүдэд зориулсан сургалттай эсэх. 	 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES
C7 Үзмэрийн тайлбар Аялагчдыг тухайн үзмэрийн байгаль, соёлын шинж чанар, ач холбогдлыг үнэн зөв тайлбарласан материалыар хангана. Тайлбар мэдээллийг орон нутгийнхны оролцоотой хамтран боловсруулж уугуул иргэд болон аялагчдад ойлгомжтой хэлээр соёлтойгоор мэдээлэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> a. Мэдээллийн тайлбар материалыг тухайн газарт нь болон урьдчилан авах боломжтой хэлбэрээр хангасан байдал. b. Тайлбар материал нь үнэн зөв, сайтар судлагдсан тухай баримт нотолгоо. c. Газар нутгийн эмзэг байдал болон үзмэрийн ач холбогдлыг тодорхойлсон тухай тайлбар материалы. d. Тайлбар мэдээллийг орон нутгийнхантай хамтран бэлтгэсэн тухай баримт нотолгоо e. Тайлбар материалыг шаардлагатай хэл дээр бичиж бэлтгэсэн байх. 	 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES
		 4 QUALITY EDUCATION

D ХЭСЭГ: Байгаль орчны тогтвортой байдал

D(a) Байгалийн өвийг хамгаалах

D1 Ариун дагшин байгаль орчны хамгаалалт

Зорих газар нь аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдийг хэмжих, хянах, хариу арга хэмжээ авах махчин зэрлэг амьтдын тархацаас урьдчилан сэргийлж экосистемийг хадгалах системтэй байна.

- Байгалийн өвийн дурсгалт газар, үнэт зүйлсийн эмзэг дагшин байдал болон хамгаалалтын статус, илэрхийлэх хэлбэр бүхий жагсаалт.
- Байгалийн өвийн дурсгалт газар болон биологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөрүүд.
- Махчин амьтдын төрөл зүйлийн тархалтыг хянах хөтөлбөрүүд.
- Байгалийн өвийн дурсгалт газар, биологийн төрөл зүйлд үзүүлэх аялал жуулчлалын сөрөг нөлөөллийг багасгах, хянах, тодорхойлох үйл ажиллагаа.
- Аялал жуулчлалаас олох орлогыг байгалийн өвийн үнэт зүйлсийг хамгаалахад ашиглах механизмыг.
- Гадны төрөл зүйлийн тархалтыг бууруулах талаар байгууллага, аялагчидтай харилцах харилцаа



D2 Байгалийн дурсгалт газар дахь аялагчдын менежмент

Зорих газар нь байгалийн дурсгалт газрууд орчмын шинж чанар, чадавхи, эмзэг байдал зэргийг харгалzan аялагчдын урсгалыг оновчтой болгож сөрөг нөлөөллийг багасгах аялагчдын менежментийн тогтолцоотой байна. Ариун дагшин газар нутагт биеэ авч явах байдлын талаархи удирдамжийг аялагчид, тур оператор, хөтөч нарт тухайн үед болон аялахаас өмнө өгдөг байна.

- Зочдын урсгал болон байгалийн дурсгалт газруудад үзүүлэх нөлөөллийг хянах, үр дүнгийн мониторинг.
- Байгалийн дурсгалт газар түүний орчимд аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийг багасгах, удирдах үйл ажиллагааны баримт нотолгоо.
- Ариун дагшин газар нутагт биеэ авч явах байдлын талаар хэвлэгдсэн удирдамжийн түгээлт, даган мөрдөж байгаа тогтмол хяналт.
- Байгалийн дурсгалт газрын аяллын менежментэд тур операторууд, хөтөч болон бусад оролцогчдын баримтлах ёс зүйн дурэм, практик.
- Аялал жуулчлалтай холбоотой байгаль орчны эрсдлүүдийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээний талаар орон нутгийн байгаль хамгаалах байгууллагатай тогтоосон хамтын ажиллагаа.
- Хөтчид зориулсан сургалттай эсэх.



D3 Зэрлэг амьтдын оршин тогтох, харилцан нөлөөлөл <p>Зорих газар нь зэрлэг амьтдын оршин тогтох, харилцан нөлөөллийн талаар орон нутаг, үндэсний болон олон улсын хууль тогтоомж, стандартуудын хэрэгжилтийг хангах системтэй байна. Зэрлэг амьтадтай шууд харилцах, хуримтлагдан бий болох нөлөөллийг харгалзан үзэж, зэрлэг байгаль дахь популяцийн амьдрах чадвар, зан авирт сөргөөр нөлөөлөхөөс зайлсхийх үүднээс хариуцлагатайгаар удирдан зохицуулна.</p>	<ul style="list-style-type: none"> a. Зэрлэг ан, амьтдын талаар тухайн зорих газарт хамаарах олон улсын, үндэсний болон орон нутгийн хууль тогтоомжийн үндэслэл /нэр, огноо/ b. Далайн болон хуурай газрын зэрлэг ан амьтдыг ажиглах олон улсын стандартанд даган орсон байх. c. Олон улсын стандартын дагуу зэрлэг амьтдын оршин тогтох, тэднийг үзэж ажиглах талаар тусгасан ёс зүйн журмыг олон нийтэд түгээх. d. Аялал жуулчлалын үйл ажиллагааны ёсзүйн дүрэм, журмыг мөрдөж буйг шалгах системтэй байх. e. Зэрлэг амьтдын амгалан тайван байдлыг хянаж, харилцан нөлөөлөх газруудад тохиолдох саад тоторыг багасгах арга хэмжээ. f. Аялагчдыг зэрлэг ан амьтдад хүрэх, хооллох гэх мэт хор хөнөөлтэй харилцан нөлөөллийн талаар мэдээллээр хангах. 	 
D4 Амьд амьтны төрөл зүйлийн хамгаалал <p>Зорих газар нь биологийн төрөл зүйлийг (амьтан, ургамал, бүх амьд организм) хамгаалдаг олон улсын, үндэсний болон орон нутгийн хууль, стандартуудыг дагаж мөрдөх системтэй байна. Үүнд зэрлэг ан амьтдын төрөл зүйл, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг хураан авах, худалдаалах, үзэсгэлэн гаргах, борлуулах зэрэг орно. Зохих тоноглол хэрэгсэл бүхий албан зөвшөөрөлтэй хүмүүс болон албан ёсоор зохион байгуулж байгаа үйл ажиллагаанаас бусад тохиолдолд зэрлэг амьтадыг барих, хорих, өсгөхийг хориглоно. Тэжээвэр болон зэрлэг амьтдыг хашиж хамгаалахдаа амьтан хамгаалах стандарттай дээд зэргээр нийцүүлсэн байна.</p>	<ul style="list-style-type: none"> a. Тухайн газар нутагт холбогдох ан, амьтад түүний төрөл зүйлийг хамгаалж хадгалах талаархи олон улсын, үндэсний болон орон нутгийн тусгай хууль, стандарт, удирдамжын үндэслэл /нэр, огноо/ b. Аялал жуулчлалын байгууллага болон хөтөч наарт өгөх хууль, стандарт, удирдамжын мэдэгдэл c. Тэжээвэр болон зэрлэг амьтдыг байршуулах, арчлах гэх мэтээр хорьж хашиж буй нөхцлийг шалгах систем. d. Зэрлэг амьтдыг барьж хамгаалах үүрэг бүхий ажилтны лиценз олгох, ур чадварыг шалгах. e. Ховордсон төрөл зүйлийг худалдаалах тухай олон улсын конвенцийг (CITES) аялал жуулчлалын салбарт сурталчилах, дагаж мөрдөж байгаа байдлыг тодорхойлох арга хэмжээ. f. Аялагчдыг ховордсон амьтдын төрөл зүйл түүний гаралтай эд зүйлсийг худалдаж авах гэх мэт ховордсон амьтны худалдаанаас зайлсхийх тухай IUCN болон CITES байгууллагуудын мэдэгдлийн талаар мэдээллээр хангах. g. Ан агуурын аливаа үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэстэй, зөв менежментийн дор ан амьтдын төрөл 	 

	<p>зүйлийг хамгаалахад чиглэсэн хандлагын нэг хэсэг байхаар зохицуулагдаж холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.</p>	
D(b) Нөөцийн менежмент		
D5 Эрчим хүчний хэмнэлт Зорих газар нь эрчим хүчний зарцуулалтыг бууруулах, түүний үр ашгийг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх зорилтуудыг хэрэгжүүлнэ. Зорих газар нь дээрхи зорилтуудад оруулсан хувь нэмрээ хэмжиж, хянах, бууруулах болон нийтэд тайлагнахад нь аж ахуйн нэгж, байгууллагуудад дэмжлэг үзүүлэх системтэй байна.	<ul style="list-style-type: none"> a. Эрчим хүчний хэрэглээний зорилтуудыг нийтэд хэвлэмэл байдлаар сурталчилаа. b. Дулаалах материалыг дэмжих, сурталчлах зэргээр эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. c. Сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалт ба нийт хангамж/ хэрэглээний хувь. d. Аж ахуйн нэгж, байгууллагуудын эрчим хүчний хэмнэлт, хяналтыг дэмжиж урамшуулах. 	 7 AFFORDABLE AND CLEAN ENERGY
D6 Усны менежмент Зорих газар нь байгууллагуудын усны хэрэглээг хэмжих, хянах, удирдах нийтэд мэдээлэхийг дэмжинэ. Зорих газар дахь усны эрсдлийг үнэлж баримтжуулсан байна. Усны эрсдэл өндөр тохиолдолд байгууллагууд усны менежментийн зорилтуудыг тодорхойлж, идэвхитэй хэрэгжүүлэх бөгөөд аялал жуулчлалын усны хэрэглээ нь орон нутгийн уугуул иргэд, экосистемийн хэрэгцээтэй зөрчилдөхгүй байх шаардлагатай.	<ul style="list-style-type: none"> a. Байгууллагууд усны хэрэглээгээ хянах, бууруулахад нь дэмжих удирдамжаар хангах. b. Усны эрсдлийг тогтмол үнэлэх хөтөлбөртэй байх. c. Усны эрсдэл өндөрөөр үнэлэгдсэн тохиолдолд усны менежментийн зорилтыг мөрдөж, хэрэгжүүлэн нийтэд мэдээлнэ. d. Аялал жуулчлалын зорилгоор ашигладаг усны хэрэглээний эх үүсвэрүүд болон хэмжээ нь экосистем болон нутгийн уугуул иргэдэд үзүүлж буй нөлөөллийн хяналт мониторинг. Аялал жуулчлалын байгууллагууд усны талаар тавьсан зорилтыг хэрэгжүүлж буй эсэхийг шалгаж сурталчилан. e. Аялагчдад усны эрсдэл болон усны хэрэглээг багасгах тухай хүргэх мэдээлэл. 	 6 CLEAN WATER AND SANITATION
D7 Усны чанар Зорих газар нь чанарын стандартуудаар үндны, амралтын болон экологийн зорилгоор хэрэглэх усны чанарыг хянадаг байна. Хяналтын үр дүн нь нийтэд нээлттэй ил тод байх бөгөөд зорих газар нь усны чанарын асуудлуудад цаг тухайд нь хариу арга хэмжээ авах системтэй байдаг.	<ul style="list-style-type: none"> a. Усны чанарын хяналт, мониторингийн хөтөлбөр. b. Усны чанарын тайлан, мэдээлэлтэй байх. c. Угаалгын усыг хянах, тогтоосон стандартад хүрсэн газруудыг тодорхойлж гэрчилгээжүүлсэн байх. d. Усны чанарыг сайжруулах үйл ажиллагааны нотолгоо. e. Аялагчдад орон нутгийн үндны усны чанарыг мэдээлж, үйлдвэрийн савласан ус ашиглахыг сурталчлан дэмжих. 	 3 GOOD HEALTH AND WELL-BEING 6 CLEAN WATER AND SANITATION

D(c) Хог хаягдлын менежмент
D8 Бохир ус

Зорих газар нь бохир усыг боловсруулах систем болон тунгаагуураас бохирын шинжилгээ хийх, цэвэршүүлэн хадгалах тухай тодорхой мөрдөх удирдамжтай байна. Зорих газар нь хог хаягдлыг зохих ёсоор боловсруулж, дахин ашиглах буюу орон нутгийн хүн ам, байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр устгана.

- Хаягдал усны ариутгалын тухай боловсруулсан дүрэм журам, удирдамж.
- Аж ахуйн нэгж, байгууллагуудад дээрх удирдамжийг хэрэгжүүлэх тогтолцоо.
- Боловсруулсан хаягдал усны сорьцийн хяналт мониторинг.
- Энэ нь хэрэглээнд нийцсэн, тохиромжтой бол аялал жуулчлалын салбарыг орон нутгийн цэвэрлэх байгууламжаар тогтвортой хангах.


D9 Хатуу хаягдал

Зорих газар нь хог хаягдлын эх үүсвэр, хэмжээг хэмжиж, бууруулах зорилт дэвшүүлэн тайлагнадаг байна. Энэхүү зорилтын хүрээнд хог хаягдлыг ангилан ялгаж салгах олон урсгал бүхий цуглуулах, дахин боловсруулах системээр хатуу хог хаягдлыг зохих ёсоор боловсруулж, холдуулан гүйцэтгэнэ. Зорих газар нь байгууллагуудыг хүнсний хаягдал зэрэг хатуу хог хаягдлыг боловсруулах, дахин ашиглах, бууруулах, зайлсхийхэд нь тусална. Нэг удаагийн хэрэглээ, ялангуяа хуванцарын хэрэглээг арилгах, бууруулах арга хэмжээ авна. Аливаа дахин ашиглагдаагүй болон боловсруулагдалгүй үлдсэн хатуу хаягдлыг аюулгүй болгож тогтмол устгана.

- Олон нийтэд ил тод зорилт, үр дүн бүхий хог хаягдлын хяналт мониторингийн хөтөлбөртэй байх.
- Хоол хүнсний хаягдал зэрэг хог хаягдлын менежментийн талаар аялал жуулчлалын байгууллагуудад нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх.
- Нэг удаагийн хэрэгсэл, ялангуяа хуванцарын хэрэглээг бууруулах нэгдсэн арга хэмжээнүүд.
- Төрийн захиргааны байгууллага, газруудын хог хаягдлын менежментийн хөтөлбөр.
- Багадаа дөрвөн урсгалаар (органик, цаас, металл, шил, хуванцар) хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах системээр хангах.
- Үлдэгдэл хог хаягдлыг зайлцуулах системээр тогтвортой хангах.
- Аялагчдыг оролцуулан хог хаягдал, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа.
- Хогийг ангилж хаях зориулалттай хогийн савны хүрэлцээ.


D10 Хүлэмжийн хийн ялгаралт болон уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах

Зорих газар нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах болон бууруулах бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх тайлагнах зорилттой байна. Аж ахуйн нэгж, байгууллагууд нь өөрийн бүхий л үйл ажиллагаандaa (бэлтгэн нийлүүлэгч, үйлчилгээ

- Тодорхой хугацаанд ялгарлыг бууруулах зорилтот хувь хэмжээг мэдээлж байх.
- Мониторинг болон бууруулах үйл ажиллагааг багтаасан уур амьсгалын жилийн тайлан мэдээ.
- Хүлэмжийн хийн ялгарлыг багасгах болон бууруулахад аялал жуулчлалын байгууллагын оролцоог дэмжих кампанит ажлууд.
- Төрийн байгууллагын үйл ажиллагаанаас



<p>үзүүлэгчдийг оролцуулан) хүлэмжийн хийг бууруулах, багасгах, үнэлж хянах, нийтэд мэдээлэхийг дэмжинэ. Үлдэгдэл ялгарлын тэнцвэржүүлэхийг нөхөн олговоор дэмждэг байна.</p>	<p>үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах арга хэмжээ.</p> <p>e. Хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцсэн нөхөн олговрын тогтолцооны талаар байгууллагууд болон аялагчдад зориулсан мэдээлэл</p>	
<p>D11 Нөлөөлөл багатай Байгальд ээлтэй тээвэр</p> <p>Зорих газар нь зорих газар луу зорчих болон тухайн газар нутагт аялахад зорчигч тээвэрээс үүсэх хийн ялгарлыг бууруулах зорилтуудтай. Агаарын бохирдол, түгжрэл, уур амьсгалын өөрчлөлтөд аялал жуулчлалаас үзүүлж буй нөлөөллийг бууруулах зорилгоор тогтвортой, хийн ялгаралт багатай тээврийн хэрэгслийг нийтийн тээвэр болон идэвхтэй аялал (алхах, унадаг дугуй унах гэх мэт)-д ашиглахыг тогтвортой нэмэгдүүлнэ.</p>	<p>a. Нийтийн тээвэр болон ялгаралт багатай тээврийн хэрэгсэл зэрэг тээврийн дэд бүтцэд тогтвортой хөрөнгө оруулалт хийх.</p> <p>b. Зорих газар луу зорчин очих болон аялахад тээврийн хэрэгслийн боломжит хувилбаруудыг аялагчдад мэдээлэх.</p> <p>c. Аялагчид ашиглаж болох боломжит тээврийн хэрэгслүүдийн талаар мэдээлэл.</p> <p>d. Дугуйгаар болон явганаар аялах боломжуудыг улам сайжруулж суртачлах.</p> <p>e. Аялал жуулчлалын зах зээлийг богино бөгөөд илүү тогтвортой тээврийн сонголтоор эрэмбэлэх.</p> <p>f. Төрийн байгууллага, аялал жуулчлалын байгууллагуудыг үйл ажиллагаандaa сөрөг нөлөөлөл багатай тээврийн хэрэгсэл ашиглаж буй эсэхээр нь эрэмбэлэх.</p>	 9 INDUSTRY, INNOVATION AND INFRASTRUCTURE  13 CLIMATE ACTION
<p>D12 Гэрэл ба дуу чимээ шуугиан</p> <p>Зорих газар нь гэрэл, дуу чимээг багасгах журам, зөвлөмжтэй байна. Мөн аж ахуйн нэгж, байгууллагуудыг холбогдох журам, зөвлөмжийг мөрдөж хэрэгжүүлэхийг дэмжинэ.</p>	<p>a. Гэрэл, дуу чимээг бууруулах удирдамжийг боловсруулж аялал жуулчлалын байгууллагуудад сурталчлах.</p> <p>b. Аялал жуулчлалаас шалтгаалан үүсэх гэрэл дуу чимээний бодит эх үүсвэрийг тодорхойлж мониторинг хийх.</p> <p>c. Нутгийн оршин суугчдад гэрэл, дуу чимээний нөлөөллийн тухай тайлагнах механизмууд, түүний мөрөөр авах арга хэмжээнүүд.</p>	 3 GOOD HEALTH AND WELL-BEING  11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES